



БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛСИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Төслөөс хамааран биологийн төрөл зүйлсийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Биологийн төрөл зүйлсийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг олон улсын тэргүүлэх туршлагын дагуу боловсруулан хэрэгжүүлэх
- Бүс нутаг дахь биологийн төрөл зүйлсийн олон янз байдалд үзүүлэх цэвэр эерэг үр нөлөөг (ЦЭҮН) бий болгох
- Цэвэр эерэг үр нөлөөллийн чиглэлээр гаргаж буй Оюу Толгойн ахиц дэвшлийг тодорхойлох мониторинг, үнэлгээний хөтөлбөрийг боловсруулах
- Бүс нутагт үр шимээ хүртээхүйц байгаль хамгааллын үйл ажиллагаанд өөрийн хувьд нэмрээ оруулах
- Уул уурхайн бүтээн байгуулалтаас Өмнийн Говийн бүс нутгийн биологийн төрөл зүйлсийн олон янз байдалд үзүүлэх, хуримтлагдах нөлөөллийг бууруулах зэрэг бүс нутгийн салбарын тэргүүлэх байр сууриа бэхжүүлэх арга замыг эрэлхийлэх.

ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Төслийн дэд бүтцийн орчны зэрлэг амьтны суурьшил шууд алдагдах, төслийн дэд бүтцээс зэрлэг амьтан дайжих замаар үүсэх шууд бус алдагдал
- Төслийн талбайд шилжин ирэх хүн амын тоо өсөн нэмэгдсэнээс үүдэн хууль бус ан агнуур, мод бэлтгэл нэмэгдэх
- Төслийн хэрэгцээг хангах эрчим хүчний шугамын барилгын ажлаас хамааран шувуудад үзүүлэх боломжит нөлөөлөл.





БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

ОЛОН УЛСЫН БОЛОН ДОТООДЫН ТЭРГҮҮЛЭХ МЭРГЭЖИЛТНҮҮД, ОРОН НУТГИЙН АРД ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ:

- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын шинжээчидтэй (Жишээ нь, Флора энд Фауна Интернейшнл, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг болон Монголын мэргэжилтнүүд) үргэлжлүүлэн хамтран ажиллаж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудтай урт хугацааны харилцаа тогтоон биологийн төрөл зүйлсийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө болон мониторингийн хөтөлбөрүүдийг олон улсын тэргүүлэх туршлагад нийцүүлэн боловсруулан, хэрэгжүүлэх
- Уул уурхайн бусад компаниуд, төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн ард иргэдтэй хамтран ажиллаж, зэрлэг амьтанд учрах аюулыг нэгдмэл байдлаар бүс нутгийн хэмжээнд зохицуулахад нь туслах.

НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ (ЗАРИМ ЖИШЭЭ):

- Туурайтан амьтдын бэлчээр нутаг хуваагдахаас сэргийлэн нүхэн гарц барьж байгуулах
- Замын дагуу постууд эсвэл замын хөдөлгөөний хяналтын бусад байгууламжуудыг байгуулан, тээврийн хэрэгсэл заагдсан замаар зорчиж буйг шалган баталгаажуулж байх
- Хууль бус ан агнуур, мод бэлтгэлийг хянах зорилгоор орон нутгийн оролцогч талуудтай хамтран ажиллах
- Зэрлэг амьтныг хууль бусаар хил нэвтрүүлэхийг хориглох зорилгоор тээврийн хэрэгсэл, агаарын хөлгийн хяналт, шалгалтыг дэмжих
- Бэлчээрийн менежментийг сайжруулах
- Хамгаалалттай газруудад нутгийн удирдлагыг бэхжүүлэх
- Орон нутгийн ойн нөөцийг аюул учруулахаас зайлсхийн ажилтнуудад галлагааны зориулалттай түлш олгох
- Төслийн хүрээнд барьж буй эрчим хүчний бүх шугам дээр шувуу үргээгч суурилуулан шувуудыг холдуулан үргээж байх
- Мэргэжилтнүүд, төр болон уул уурхайн бусад компаниудтай хамтран зэрлэг ан амьтны мониторингийг тогтмол үргэлжлүүлэх.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Биологийн төрөл зүйлсийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г www.ot.mn цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.